



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 364

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168, 328, 2022 оны 293 дугаар тогтоолын 3.4, 5.2 дахь заалт, 2023 оны 306 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2нэрийн, нийт 121,503,300.00 (нэг зуун хорин нэгэн сая таван зуун гурван мянга гурван зуу) төгрөгийн балансын үнэ, 64,801,760.00 (жаран дөрвөн сая найман зуун нэг мянга долоон зуун жар) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Ой мод сургалт, судалгааны хүрээлэнд балансаас балансад шилжүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор Т.Намнан, Ой модны сургалт судалгааны хүрээлэнгийн захирал Б.Билэгт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Хаалтын балансыг гарган баталгаажуулж, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг улсын бүртгэлээс хасуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.4. Газар эзэмших эрхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Ой мод сургалт судалгааны хүрээлэнгийн нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001807

17-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
36.4 дугаар тогтоолын хавсралт

ШУТИС-ийн үйлдвэрлэл технологийн сургуулийн
мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн балансаас шутис-ийн харъяа ой модны
сургалт, судалгааны хүрээлэнд балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Хэм- жих нэгж	Тоо хэм жээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Канад загварын модон байшин-2	12/29/2015	ш	1	87,802,200.00	46,827,840.03	40,974,359.97
2	Канад загварын модон байшин	12/30/2015	ш	1	33,701,100.00	17,973,919.97	15,727,180.03
	НИЙТ ДҮН			2	121,503,300.00 (нэг зуун хорин нэгэн сая таван зуун гурван мянга гурван зуу)	64,801,760.00 (жаран дөрвөн сая найман зуун нэг мянга долоон зуун жар)	56,701,540.00 (тавин зургаан сая долоон зуун нэг мянга таван зуун дөч)